ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:**ӨВА-2022/8/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өвөрхангай аймаг<br>Арвайхээр сум<br>2022 он | Өвөрхангай аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал<br>Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Гансүх<br>Утас: 99328832 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com<br><br>Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг<br>Утас: 70323108 Цахим хаяг:<br><br>Аудитор: Д.Дашзэвэг<br>Утас: 95329926 Цахим хаяг: dashzeveg_d@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. Аудитын санал дүгнэлт.......................................................**Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 2

3. Аудитын тайлан ................................................................................................... 10

   3.1 Ерөнхий зүйл ................................................................................................ 10

   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт............................................... 10

   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .................................................... 11

   3.4 Материаллаг байдал...................................................................................... 11

   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ................................................................ 11

   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ............................................... 11

   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..................................... 12

   3.8 Аудитын гол асуудал..................................................................................... 12

   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал................ 12

   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..................................................................... 13

   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ...................................................... 13

4. Аудитын илрүүлэлт.................................................................................................. 13

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .......................................................... 14


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022. 02. 28 № 315.

танай ____________-ны №____________-т

БОГД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭ АРИУНАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46786956.95** | **367618969.75** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 5404780.05 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 5404780.05 |
| **3121** | **Төгрөг** | 0.00 | 5404780.05 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 5314780.05 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | 90000.00 |
| **33** | **АВЛАГА** | 4204246.70 | 223336603.28 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 4204246.70 | 222945200.00 |
| 33402 | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | | 391403.28 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42582710.25 | 138877586.42 |
| **351** | **Түүхий эд материал** | 15286109.75 | 92688307.42 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 9846611.25 | 24579369.12 |
| 35130 | Эм боох материал | 5439498.50 | 68108938.30 |
| **354** | **Хангамжийн материал** | 27296600.50 | 46189279.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 96800.00 | 502800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19862276.00 | 34476076.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4200000.00 | 6000000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2337824.50 | 5045403.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 799700.00 | 165000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1142169236.30** | **1025647589.60** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1142169236.30 | 1025647589.60 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1123089236.30 | 1006567589.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 581927131.00 | 581927131.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -39403224.49 | -61868948.65 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 80136434.00 | 80136434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -25858247.30 | -40860986.42 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 839875905.06 | 865666655.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -322663507.10 | -428604932.61 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27997662.47 | 31447662.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19047917.06 | -21275425.25 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1000000.00 | 1000000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -875000.28 | -1000000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19080000.00 | 19080000.00 |
| 39301 | Програм хангамж | 490000.00 | 490000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -490000.00 | -490000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 19080000.00 | 19080000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1188956193.25** | **1393266559.35** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4204246.70** | **216954783.19** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4204246.70 | 216954783.19 |
| **413** | **Өглөг** | 4204246.70 | 216954783.19 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 101250000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2965209.19 | 0.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 1239037.51 | 115704783.19 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1239037.51 | 115704783.19 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1184751946.55** | **1176311776.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1184751946.55 | 1176311776.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 290542267.05 | 290542267.05 |
| 51101 | Өмч: - төрийн | 290542267.05 | 290542267.05 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 458689148.37 | 450248977.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 458689148.37 | 458689148.37 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -8440170.39 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 435520531.13 | 435520531.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1188956193.25** | **1393266559.35** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **771307210.00** | **1303880388.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **176398200.00** | **279953448.59** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 176398200.00 | 279953448.59 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 88199100.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 88199100.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй авсан орлого-үндсэн хөрөнгө | 86900000.00 | 16960950.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан орлого-Бараа материал | 1299100.00 | 262992498.59 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **594909010.00** | **1023926940.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 482924900.00 | 499540000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 482924900.00 | 499540000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11387280.00 | 415096100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11387280.00 | 39721700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 375374400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43728100.00 | 49070200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43728100.00 | 49070200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 56868730.00 | 60220640.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 56868730.00 | 60220640.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **721796565.15** | **1312320558.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **721796565.15** | **1312320558.98** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 718176395.53 | 1272621679.61 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 377882875.90 | 532641084.82 |
| 210101 | Үндсэн цалин | 237932420.00 | 249664340.00 |
| 210102 | Нэмэгдэл | 107793665.00 | 238699835.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5820795.00 | 6760000.00 |
| 210104 | Урамшуулал | 26335995.90 | 37516909.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46906680.29 | 55245870.34 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31992880.29 | 38853441.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3728400.00 | 4239788.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2982800.00 | 3391830.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 745700.00 | 796437.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7456900.00 | 7964372.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42220410.00 | 45571320.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4738718.00 | 4135806.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33178992.00 | 37132814.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4302700.00 | 4302700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29391084.00 | 50209790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1097930.00 | 2810840.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18676954.00 | 28991550.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1632000.00 | 1922500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500000.00 | 175200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7334200.00 | 16309700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 150000.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 63158672.31 | 408736357.12 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 54924733.31 | 383572235.62 |
| 210502 | Хоол, хүнс | 8233939.00 | 25164121.50 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1414000.00 | 19810000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 965000.00 | 2000000.00 |
| 210604 | Урсгал засвар | 449000.00 | 17810000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1555200.00 | 1505700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1555200.00 | 1505700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1674860.00 | 1324160.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12000.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1083460.00 | 1180000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97800.00 | 98000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 8000.00 | 8000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 41600.00 | 38160.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153972613.03 | 157577396.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12679480.00 | 11815000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 141293133.03 | 145762396.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3620169.62 | 39698879.37 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 39200000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 39200000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3620169.62 | 498879.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3620169.62 | 498879.37 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 49510644.85 | -8440170.39 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 49510644.85 | -8440170.39 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 290,542,267.05 | 435,520,531.13 | 458,689,148.37 | 1,184,751,946.55 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **290,542,267.05** | **435,520,531.13** | **458,689,148.37** | **1,184,751,946.55** |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | **290,542,267.05** | **435,520,531.13** | **458,689,148.37** | **1,184,751,946.55** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **290,542,267.05** | **435,520,531.13** | **458,689,148.37** | **1,184,751,946.55** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **290,542,267.05** | **435,520,531.13** | **458,689,148.37** | **1,184,751,946.55** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -8,440,170.39 | -8,440,170.39 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **290,542,267.05** | **435,520,531.13** | **450,248,977.98** | **1,176,311,776.16** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 594909010.00 | 800981740.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 594909010.00 | 800981740.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 482924900.00 | 499540000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 482924900.00 | 499540000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 11387280.00 | 192150900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11387280.00 | 39721700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 152429200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 43728100.00 | 49070200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 43728100.00 | 49070200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 56868730.00 | 60220640.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 56868730.00 | 60220640.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **592402010.00** | **783297161.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **592402010.00** | **783297161.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **584577593.68** | **743598282.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 375656499.90 | 432359296.82 |
| 210101 | Үндсэн цалин | 235706044.00 | 249664340.00 |
| 210102 | Нэмэгдэл | 107793665.00 | 138418047.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5820795.00 | 6760000.00 |
| 210104 | Урамшуулал | 26335995.90 | 37516909.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46605499.78 | 55873599.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31691699.78 | 39481170.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3728400.00 | 4239788.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2982800.00 | 3391830.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 745700.00 | 796437.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7456900.00 | 7964372.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42220410.00 | 45571320.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4738718.00 | 4135806.00 |
| 210302 | Түлш, халаалт | 33178992.00 | 37132814.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4302700.00 | 4302700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33560354.00 | 41150400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1200000.00 | 2160000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21678354.00 | 23326000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1632000.00 | 2307500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500000.00 | 500000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8550000.00 | 12856900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 67421800.00 | 142133604.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 54355600.00 | 114763004.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10166200.00 | 25370600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2900000.00 | 2000000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2943000.00 | 12880200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2943000.00 | 9880200.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 3000000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1555200.00 | 1505700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1555200.00 | 1505700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1675760.00 | 1324162.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12000.00 | 1.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432000.00 | 1.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1084360.00 | 1180000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97800.00 | 98000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 8000.00 | 8000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 41600.00 | 38160.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12939070.00 | 10800000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12939070.00 | 10800000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7824416.32** | **39698879.37** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 39200000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 39200000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 7824416.32 | 498879.37 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7824416.32 | 498879.37 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2507000.00** | **17684578.05** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2507000.00** | **12279800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2507000.00** | **12279800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2507000.00 | 12279800.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2507000.00 | 12279800.00 |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2507000.00** | **-12279800.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 5404778.05 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 5404780.05 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны төлөвлөгөө | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны төлөвлөгөө | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| **21** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 575970900.00 | 575697313.68 | 605499100.00 | 613976680.58 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 575970900.00 | 575697313.68 | 605499100.00 | 613976680.58 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 575970900.00 | 575697313.68 | 605499100.00 | 613976680.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 372844000.00 | 372843999.90 | 390116000.00 | 392095900.82 |
| 210101 | Үндсэн цалин | 231598000.00 | 232893544.00 | 235598000.00 | 222597319.00 |
| 210102 | Нэмэгдэл | 111078000.00 | 107793665.00 | 111078000.00 | 125221672.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5808000.00 | 5820795.00 | 8100000.00 | 6760000.00 |
| 210104 | Урамшуулал | 24360000.00 | 26335995.90 | 35340000.00 | 37516909.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46605500.00 | 46605499.78 | 52665700.00 | 50686599.13 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31691600.00 | 31691699.78 | 37061300.00 | 35683195.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3728400.00 | 3728400.00 | 3901200.00 | 3892531.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2982900.00 | 2982800.00 | 3120700.00 | 3114025.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 745600.00 | 745700.00 | 780200.00 | 726985.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7457000.00 | 7456900.00 | 7802300.00 | 7269861.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45237100.00 | 42220410.00 | 46070200.00 | 45571320.63 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4264800.00 | 4738718.00 | 4441100.00 | 4135806.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36669600.00 | 33178992.00 | 37326400.00 | 37132814.63 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4302700.00 | 4302700.00 | 4302700.00 | 4302700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35580500.00 | 29903974.00 | 35960400.00 | 35960400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1200000.00 | 1200000.00 | 1500000.00 | 1500000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23113000.00 | 17571974.00 | 22000000.00 | 22000000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1767500.00 | 1632000.00 | 2007500.00 | 2007500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500000.00 | 500000.00 | 500000.00 | 500000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9000000.00 | 9000000.00 | 9952900.00 | 9952900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 54777800.00 | 63421800.00 | 56958800.00 | 65938300.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 38027800.00 | 50355600.00 | 39958800.00 | 48938300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13850000.00 | 10166200.00 | 15000000.00 | 15000000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2900000.00 | 2900000.00 | 2000000.00 | 2000000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5000000.00 | 5000000.00 | 10760000.00 | 10760000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5000000.00 | 5000000.00 | 7760000.00 | 7760000.00 |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 0.00 | 3000000.00 | 3000000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1200000.00 | 1086800.00 | 840000.00 | 840000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1200000.00 | 1086800.00 | 840000.00 | 840000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1786800.00 | 1675760.00 | 1328000.00 | 1324160.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 12000.00 | 0.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450000.00 | 432000.00 | 0.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1189400.00 | 1084360.00 | 1180000.00 | 1180000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 97800.00 | 97800.00 | 98000.00 | 98000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 8000.00 | 8000.00 | 8000.00 | 8000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 41600.00 | 41600.00 | 42000.00 | 38160.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12939200.00 | 12939070.00 | 10800000.00 | 10800000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12939200.00 | 12939070.00 | 10800000.00 | 10800000.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **0.0** | 0.00 | 5314780.05 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **11387280.00** | **181101400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11387280.00** | **181101400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 11387280.00 | 141901400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2812500.00 | 40263396.00 |
| 210101 | Үндсэн цалин | 2,812,500.00 | 7,067,021.00 |
| 210102 | Нэмэгдэл | - | 13,196,375.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 5187000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 3,797,975.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 347,257.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 277,805.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 69,452.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 694,511.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4106380.00 | 5640000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 660,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,106,380.00 | 1,326,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 3,354,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4000000.00 | 76195304.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,000,000.00 | 65,824,704.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 10,370,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 13950000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 13,950,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 468400.00 | 665700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 468,400.00 | 665,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 39200000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 0.00 | 39200000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 39,200,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 92,663,700.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 92,663,700.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дэлгээнхайрхан Уул Аудит ХХК-ийн аудитор Д.Дашзэвэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д. Гансух, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дэлгээнхайрхан Уул Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

**Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл:**

Богд сумын Эрүүл мэндийн төв нь “Иргэдэд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай,үйлчлүүлэгчид ээлтэй,тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж ,хүн амын эрүүл мэндийг сайжруулан зөв дадал заншилтай эрүүл иргэн төлөвшүүлэхэд оршино.” эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зарлага 721,8 сая төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайлант онд 1550,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байсан бол 12979,8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 16960,9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээр тус тус нэмэгдэж, 1579747,9 мянган төгрөгийн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын хувьд 42582,7 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 305841,0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч , 2500,0 мянган төгрөг бараа материал хандиваар авч, 472538,6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 138877,6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Авлага оны эхэнд 4204,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 223336,6 мянган төгрөг болж 219132,4 мянган төгрөгөөр өссөн байна. Өглөг оны эхэнд 4204,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 216954,8 мянган төгрөг болж 212750,6 мянган төгрөгөөр өссөн байна. Авлага өглөгийн өссөн шалтгаан нь санхүүжилт ондоо багтаж бүрэн ороогүйтэй холбоотой.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон 26147,5 мянган төгрөг, эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үйл ажиллагааны зардалд 442781,7 мянган төгрөг үүнээс: Цалин урамшуулалд 390116,0 мянган төгрөг, шимтгэлд 52665,7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад 49070,2 мянган төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардалд 80286,8 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон 33360,4 мянган төгрөг, эмнэлгийн тусламж үйлчилгээний үндсэн үйл ажиллагааны зардалд 570155,7 мянган төгрөг үүнээс: Цалин урамшуулалд 392095,9 мянган төгрөг, шимтгэлд 50686,6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад 48571,3 мянган төгрөг, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардалд 78302,9 мянган төгрөг оны эцэст 5314,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 181101,4 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсгийн талаар тодруулах мэдээлэл байхгүй.

## 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.
Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын чиглэлээр аудитын горим сорил гүйцэтгэсэн.
Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

. Шилэн дансны цахим хуудсанд 26 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд аудитын түүвэрт хамрагдсан.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авлага өглөгийн барагдуулалтыг анхаарах шаардлагатай.

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11,0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 11,0 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулсан болно.

**4,1 Төлбөрийн акт**

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилоор төлбөрийн акт тогтоохоор зөрчил илрээгүй

**4,2 Аудитын залруулга**

Ковид-19 короно вирусийн илрүүлэх шинжилгээний төлбөрийн 10959,5 мянган төгрөгийн орлого болон түүний зарцуулалтыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д ."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ": 14.4.5.-д “бүх орлого”; 14.4.6-д."бүх зардал"; МУ-ын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01-р сарын 12-ны өдрийн 05, А/112 тоот тушаалаар баталсан Коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээг хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах журмын 3 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.Дээрх орлого болон түүний зарцуулалтыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгасан болно.

**4.3 Албан шаардлага**

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорилоор албан шаардлага өгөхөөр зөрчил илрээгүй

**4.4 Зөвлөмж**

*Илрүүлэлт:*

Шилэн дансны системд нийт 119 мэдээлэл оруулахаас 89 мэдээллийг хугацаанд оруулж 26 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан ба 2 мэдээлэл бэлэн болоогүйгээс, 2 мэдээллийг огт оруулаагүй байна

*Өгсөн зөвлөмж:*

Цаашид шилэн дансны хуулийн дагуу мэдээллийг хугацаа хожимдуулалгүй бүрэн оруулж байхыг зөвлөмж болгов.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Богд сумын Эрүүл мэндийн төв | 2 | 11,0 | 1 | 11,0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Д.ДАШЗЭВЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 25-НИЙ ӨДӨР